**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2025/026/НА-СТА-ТӨҮГ**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас:261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn<br>Ахлах аудитор/аудитор: А.Даваадорж<br>Утас:263533 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн захирал: Д.Хандмаа<br>Утас:70111721 Цахим хаяг: info@sda-audit.mn |

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1066

танай ____________-ны №____________-т

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН РЕКТОР
Б.ДАМДИНДОРЖ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлж үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн төсвийг үрэлгэн зарцуулсан, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохин байгуулаагүй, авлага, өглөгийн тооцоог тухай бүр хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, бүрдэл дутуу анхан шатны баримтыг үндэслэж ажил гүйлгээ бүртгэлд тусгасан зэрэг 1,083.6 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлын онцолсон хэсэг**

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн эмнэлгийн тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын

Засгийн газар хооронд байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд “Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Эмнэлгүүдийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл”-ийг хэрэгжүүлж, 2024 онд нийт 27,231.8 сая төгрөгийн өртөг бүхий 110 нэр төрлийн шинэ тоног төхөөрөмжийг хүлээн авч, ашиглалтад оруулсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тус сургуулийн газар болон үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын байдалд хийсэн хяналт шалгалтын дүнгийн мөрөөр 29,510.6 сая төгрөгийн дуусаагүй барилга байгууламжийг “Барилга байгууламж, орон сууц” дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус сургууль дэлхийд өрсөлдөх чадвартай эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх бодлого, зорилтын хүрээнд хөгжлийн бодлогын баримт бичгээ шинэчлэн, англи хэлээр заах хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх, гадаад багшийн эзлэх хувийг өсгөх, олон улсад эрэмбэлүүлэх чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2025\0317 SNAG-23.Docx

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **58,976,506,478.67** | **38,406,930,684.66** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **25,327,076,338.62** | **13,145,357,894.52** |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | **920,000.00** | **268,400.00** |
| 31110 | Төгрөг | 920,000.00 | 268,400.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **19,770,762,431.64** | **9,409,071,995.47** |
| **3121** | **Төгрөг** | **16,910,104,586.55** | **7,337,474,075.17** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 652,285,465.35 | 480,966,828.74 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 16,257,819,121.20 | 6,856,507,246.43 |
| **3122** | **Гадаад валют** | **2,860,657,845.09** | **2,071,597,920.30** |
| 31223 | Арилжааны банк дахь харилцах | 2,860,657,845.09 | 2,071,597,920.30 |
| 31400 | Замд яваа мөнгөн хөрөнгө | 5,407,900.00 | 13,718,599.82 |
| 31500 | Хадгаламж | 5,549,986,006.98 | 3,722,298,899.23 |
| **33** | **АВЛАГА** | **21,988,191,541.07** | **12,179,207,337.92** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 188,529.13 | 7,542,352.78 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 14,785,225,235.66 | 3,462,990,169.40 |
| **335** | **Бусад авлага** | **7,202,777,776.28** | **8,708,674,815.74** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 7,127,914,756.63 | 8,632,897,126.30 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 74,863,019.65 | 75,777,689.44 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **481,469,369.86** | **953,029,749.86** |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | **481,469,369.86** | **953,029,749.86** |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 137,106,050.00 | 627,750,850.00 |
| 34712 | Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 344,363,319.86 | 325,278,899.86 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **11,179,769,229.12** | **12,129,335,702.36** |
| **351** | **Түүхий эд материал** | **9,270,621,313.01** | **9,830,878,603.04** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,518,995,874.75 | 5,158,474,811.55 |
| 35130 | Эм боох материал | 4,751,625,438.26 | 4,672,403,791.49 |
| **354** | **Хангамжийн материал** | **1,902,847,916.11** | **2,293,917,099.32** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 156,107,445.03 | 199,472,979.05 |
| 35420 | Аж ахуйн материал | 769,148,047.80 | 906,168,769.57 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 131,970,078.82 | 89,050,859.41 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,095,118.19 | 4,465,154.02 |
| 35450 | Барилгын засварын материал | 44,298,165.23 | 29,604,835.23 |
| 35460 | Хүнсний материал | 36,548,470.65 | 32,820,292.73 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 761,680,590.39 | 1,032,334,209.31 |
| 35600 | Мал амьтад | 6,300,000.00 | 4,540,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **282,989,974,692.11** | **317,936,055,544.70** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **282,989,974,692.11** | **317,936,055,544.70** |

| | | | |
|---|---|---|---|
| **392** | **Биет хөрөнгө** | **262,283,963,984.62** | **297,311,613,885.61** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 204,571,623,470.26 | 241,285,991,035.72 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (13,306,907,616.29) | (18,052,982,580.74) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,087,516,933.67 | 1,537,516,933.67 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (708,683,211.50) | (808,631,209.90) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 72,616,624,426.93 | 109,334,089,341.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (44,354,173,058.47) | (55,385,249,980.66) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 8,901,070,529.90 | 10,007,766,805.70 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (5,548,000,512.49) | (6,466,785,406.43) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 226,383,955.88 | 249,623,355.88 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (114,135,279.48) | (132,204,259.92) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 530,989,540.73 | 583,981,406.13 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (326,275,577.95) | (353,771,105.52) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 37,528,103,670.33 | 14,250,622,966.65 |
| 39217 | Ном | 1,179,826,713.10 | 1,261,646,583.10 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **20,706,010,707.49** | **20,624,441,659.09** |
| 39301 | Программ хангамж | 660,366,407.00 | 658,058,837.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (401,508,845.74) | (447,461,793.67) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 20,488,018,867.00 | 20,488,018,867.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (40,865,720.77) | (74,174,251.24) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **341,966,481,170.78** | **356,342,986,229.36** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **6,773,755,417.15** | **11,936,150,280.19** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **6,773,755,417.15** | **11,936,150,280.19** |
| **413** | **Өглөг** | **2,938,370,367.82** | **4,594,140,097.17** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 233,763,273.34 | 137,887,242.12 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 7,150,000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | **2,704,607,094.48** | **4,449,102,855.05** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 2,704,432,124.48 | 4,442,054,131.05 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 174,970.00 | 7,048,724.00 |
| **414** | **Урьдчилж орсон орлого** | **3,835,385,049.33** | **7,342,010,183.02** |
| 41420 | Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого | 3,659,968,891.33 | 7,104,702,393.02 |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 175,416,158.00 | 237,307,790.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **335,192,725,753.63** | **344,406,835,949.17** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **335,192,725,753.63** | **344,406,835,949.17** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 13,733,182,426.15 | 13,733,182,426.15 |
| 51101 | Өмч: - төрийн | 13,733,182,426.15 | 13,733,182,426.15 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **296,331,169,754.70** | **305,545,279,950.24** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 295,896,211,904.61 | 294,677,780,160.12 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 434,957,850.09 | 10,867,499,790.12 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 25,128,373,572.78 | 25,128,373,572.78 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **341,966,481,170.78** | **356,342,986,229.36** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан
/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **94,604,727,526.63** | **125,285,092,139.14** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **63,197,819,825.63** | **84,904,121,238.14** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **62,990,124,015.29** | **55,887,301,787.05** |
| 120002 | Хүүгийн орлого | 1,277,933,323.46 | 491,261,414.70 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **60,888,337,115.67** | **54,504,374,822.97** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 45,242,229,651.05 | 35,300,921,985.77 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,672,327,086.07 | 7,109,736,400.57 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 2,300,201,744.45 | 2,722,041,306.69 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 7,673,578,634.10 | 9,371,675,129.94 |
| 120005 | Түрээсийн орлого | 111,478,857.35 | 201,793,368.00 |
| 120009 | Бусад орлого | 712,374,718.81 | 689,872,181.38 |
| **122** | **Тусламжийн орлого** | **207,695,810.34** | **29,016,819,451.09** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 207,695,810.34 | 1,785,033,461.59 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | - | 27,231,785,989.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **31,406,907,701.00** | **40,380,970,901.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **8,754,000,000.00** | **10,304,471,000.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 8,754,000,000.00 | 10,304,471,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **2,510,000,000.00** | **75,000,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,510,000,000.00 | 75,000,000.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **1,002,878,691.00** | **5,967,811,860.00** |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 5,687,097,880.00 |
| 133004 | Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт | 692,582,394.00 | 234,539,500.00 |
| 133005 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | 310,296,297.00 | 46,174,480.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **19,140,029,010.00** | **24,033,688,041.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 19,140,029,010.00 | 24,033,688,041.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **94,133,086,980.61** | **114,387,515,912.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **94,133,086,980.61** | **114,357,015,912.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **93,245,488,111.21** | **113,623,034,623.37** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **48,934,972,613.25** | **60,660,631,810.50** |
| 210101 | Үндсэн цалин | 29,678,218,150.89 | 35,202,757,349.10 |
| 210102 | Нэмэгдэл | 7,947,414,894.76 | 11,509,314,234.46 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,396,183,700.00 | 3,264,364,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 15,407,603.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 8,913,155,867.60 | 10,668,788,623.44 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **5,290,889,140.47** | **6,276,441,286.39** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,289,871,549.95 | 6,264,098,797.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,017,590.52 | 12,286,113.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 56,376.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **3,292,707,083.33** | **3,674,098,233.29** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,588,307,281.02 | 1,658,254,814.34 |
| 210302 | Түлш, халаалт | 1,030,186,484.50 | 1,267,608,837.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 674,213,317.81 | 747,291,061.35 |
| 210304 | Байрны түрээс | | 943,520.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,878,820,092.30** | **3,178,724,842.33** |
| 210401 | Бичиг хэрэг | 624,069,335.88 | 667,425,420.51 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 109,062,272.43 | 106,726,152.51 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 227,557,871.70 | 275,667,612.89 |
| 210404 | Ном, хэвлэл | 62,126,562.92 | 182,404,734.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 88,509,225.00 | 307,396,955.79 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 712,590,887.55 | 977,810,170.97 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 14,705,960.00 | 30,901,725.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 40,197,976.82 | 630,392,070.66 |
| **2105** | **Нормативт зардал** | **8,736,715,241.27** | **11,993,217,044.29** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 7,966,442,680.07 | 11,368,113,607.78 |
| 210502 | Хоол, хүнс | 734,516,089.20 | 591,752,436.61 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 35,756,472.00 | 33,350,999.90 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,952,542,541.12** | **3,076,084,716.08** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 273,608,292.96 | 185,952,701.67 |
| 210602 | Тавилга | 4,451,500.00 | 71,046,461.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,007,002.00 | 621,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,672,475,746.16 | 2,818,464,453.41 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **436,819,898.10** | **642,612,569.52** |
| 210701 | Гадаад албан томилолт | 209,315,967.10 | 435,115,062.40 |
| 210702 | Дотоод албан томилолт | 181,702,827.00 | 166,398,029.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 45,801,104.00 | 41,099,478.12 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,165,110,557.58** | **2,171,678,104.06** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,867,541,747.47 | 1,854,923,811.84 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 75,965,262.00 | 110,106,170.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,885,970.00 | 2,359,830.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 988,404.00 | 1,419,881.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 2,898,162.00 | 64,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 56,859,286.43 | 144,814,377.50 |
| 210807 | Газрын төлбөр | 352,692.00 | 178,384.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 157,619,033.68 | 57,811,649.72 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **19,556,910,943.79** | **21,949,546,016.91** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 238,522,040.58 | 541,607,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,428,587,413.10 | 4,887,590,988.78 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 13,889,801,490.11 | 16,520,347,228.13 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **887,598,869.40** | **733,981,288.77** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **848,561,269.40** | **733,981,288.77** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 108,873,294.00 | 19,072,492.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,800,000.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 475,188,644.00 | 437,760,610.77 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 243,699,331.40 | 277,148,186.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **237,600.00** | **-** |
| 213501 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 237,600.00 | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **38,800,000.00** | **30,500,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **38,800,000.00** | **30,500,000.00** |
| 220001 | Барилга байгууламж | 19,000,000.00 | |
| 221001 | Их засвар | - | 30,500,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 19,800,000.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **471,640,546.02** | **10,897,576,227.00** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **145,443,974.43** | **74,734,965.31** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 145,443,974.43 | 74,734,965.31 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **182,126,670.36** | **104,811,402.19** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | - |
| 225004 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 182,126,670.36 | 104,811,402.19 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **(36,682,695.93)** | **(30,076,436.88)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **434,957,850.09** | **10,867,499,790.12** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **13,719,102,426.15** | **24,604,968,444.05** | **295,907,211,136.57** | **334,231,282,006.77** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 14,080,000.00 | 523,405,128.73 | -10,999,231.96 | 526,485,896.77 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **13,733,182,426.15** | **25,128,373,572.78** | **295,896,211,904.61** | **334,757,767,903.54** |
| Тайлант үеийн үр дүн | | | 434,957,850.09 | 434,957,850.09 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **13,733,182,426.15** | **25,128,373,572.78** | **296,331,169,754.70** | **335,192,725,753.63** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 9,249,057.65 | 9,249,057.65 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **13,733,182,426.15** | **25,128,373,572.78** | **296,340,418,812.35** | **335,201,974,811.28** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | -1,662,638,652.23 | -1,662,638,652.23 |
| Тайлант үеийн үр дүн | | | 10,867,499,790.12 | 10,867,499,790.12 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **13,733,182,426.15** | **25,128,373,572.78** | **305,545,279,950.24** | **344,406,835,949.17** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан
/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **80,719,596,280.64** | **98,526,554,072.14** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **52,396,353,883.64** | **61,264,985,469.84** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **52,396,353,883.64** | **61,264,985,469.84** |
| 120002 | Хүүгийн орлого | 1,192,595,369.96 | 457,920,444.15 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **50,635,830,356.49** | **59,941,010,711.50** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 39,426,685,763.63 | 46,362,389,132.31 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,913,562,848.41 | 10,856,536,272.50 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 2,295,581,744.45 | 2,722,085,306.69 |
| 120005 | Түрээсийн орлого | 111,090,857.35 | 145,771,666.00 |
| 120009 | Бусад орлого | 456,837,299.84 | 720,282,648.19 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **28,323,242,397.00** | **37,261,568,602.30** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **8,943,665,800.00** | **15,991,568,880.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 5,687,097,880.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 8,754,000,000.00 | 10,304,471,000.00 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 189,665,800.00 | - |
| 1330 | **Төсвийн захирагчдаас** | **5,011,116,217.00** | **280,713,980.00** |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 18,000,000.00 | - |
| 133002 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,864,167,920.00 | - |
| 133004 | Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт | 2,818,652,000.00 | 234,539,500.00 |
| 133005 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | 310,296,297.00 | 46,174,480.00 |
| 1340 | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **14,368,460,380.00** | **20,989,285,742.30** |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | 947,283.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 14,368,460,380.00 | 20,988,338,459.30 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **81,457,748,073.60** | **98,951,428,401.26** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **81,457,748,073.60** | **98,951,428,401.26** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **78,734,634,637.30** | **98,208,464,364.49** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **48,251,166,620.70** | **59,527,123,783.63** |
| 210101 | Үндсэн цалин | 39,581,077,447.90 | 49,458,882,181.41 |
| 210102 | Нэмэгдэл | 276,521,642.40 | |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 59,704,000.00 | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 8,333,863,530.40 | 10,068,241,602.22 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **5,301,621,018.48** | **7,148,219,943.34** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,917,233,190.03 | 6,699,843,056.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 95,972,283.25 | 112,778,669.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 77,091,338.21 | 72,783,635.48 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,617,253.75 | 46,773,649.90 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 192,706,953.24 | 216,040,932.15 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **3,280,938,512.07** | **3,657,701,129.43** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,506,472,482.15 | 1,650,832,854.34 |
| 210302 | Түлш, халаалт | 1,098,546,093.52 | 1,267,106,019.92 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 675,919,936.40 | 739,762,255.17 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,964,651,317.46** | **3,598,568,718.09** |
| 210401 | Бичиг хэрэг | 454,516,860.32 | 580,838,852.86 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 150,292,030.20 | 99,465,649.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 242,941,206.41 | 292,670,917.03 |
| 210404 | Ном, хэвлэл | 156,174,839.73 | 266,963,683.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 287,752,165.00 | 286,698,776.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 672,974,215.80 | 2,071,930,840.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **5,908,943,620.63** | **10,127,806,391.39** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,128,566,720.63 | 9,280,125,332.39 |
| 210502 | Хоол, хүнс | 666,521,323.00 | 615,387,359.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 113,855,577.00 | 232,293,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,952,936,650.82** | **4,677,162,537.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 950,032,538.00 | 2,153,892,710.00 |
| 210602 | Тавилга | 739,177,714.00 | 113,512,660.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 15,593,302.00 | 24,427,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,248,133,096.82 | 2,385,329,467.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **453,783,991.09** | **586,361,133.32** |
| 210701 | Гадаад албан томилолт | 251,356,574.09 | 375,701,215.20 |
| 210702 | Дотоод албан томилолт | 152,356,457.00 | 170,495,456.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 50,070,960.00 | 40,164,462.12 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,692,102,960.77** | **2,496,380,836.85** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,488,120,647.67 | 1,758,817,138.14 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 68,163,261.00 | 127,222,620.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 11,397,129.90 | 2,216,830.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,554,066.00 | 1,364,481.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 2,989,250.00 | 141,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 66,364,982.43 | 591,636,622.50 |
| 210807 | Газрын төлбөр | 352,692.00 | 178,384.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 52,160,931.77 | 14,803,761.21 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **6,928,489,945.28** | **6,389,139,891.44** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,921,641,174.22 | 4,536,211,283.47 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,006,848,771.06 | 1,852,928,607.97 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,723,113,436.30** | **742,964,036.77** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **858,945,516.30** | **742,964,036.77** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 40,725,332.00 | 13,902,492.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 60,800,000.00 | 28,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 473,188,644.00 | 443,642,694.77 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 284,231,540.30 | 257,418,850.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,864,167,920.00** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,864,167,920.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(738,151,792.96)** | **(424,874,329.12)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **9,004,632,982.00** | **11,726,767,678.10** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,004,632,982.00** | **11,726,767,678.10** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **9,004,632,982.00** | **11,726,767,678.10** |
| 220001 | Барилга байгууламж | 7,438,631,871.00 | 5,784,358,065.00 |
| 221001 | Их засвар | 337,511,351.00 | 2,779,886,581.10 |
| 222001 | Тавилга эд хогшил | 134,416,920.00 | 646,884,073.00 |
| 222002 | Тоног төхөөрөмж | 953,080,480.00 | 2,193,536,319.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 19,800,000.00 | 199,400,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 255,609,280.00 | 122,702,640.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(9,004,632,982.00)** | **(11,726,767,678.10)** |
| 25 | **Санхүүгийн үйл ажиллагааны зардал** | 36,682,695.93 | (30,076,436.88) |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүү | 36,682,695.93 | 30,076,436.88 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(36,682,695.93)** | **(30,076,436.88)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (9,779,467,470.89) | (12,181,718,444.10) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 35,106,543,809.51 | 25,327,076,338.62 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 25,327,076,338.62 | 13,145,357,894.52 |

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөг/

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023 оны гүйцэтгэл | 2024 он | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **1** | **Нийт орлого** | **сая төг** | **94,604.7** | **110,828.0** | **125,285.20** | **-14,457.20** | **113.05** |
| 1.1 | Төсвийн санхүүжилтийн орлого | сая төг | 31,406.9 | 31,015.8 | 24,033.70 | 6,982.10 | 77.5 |
| 1.2 | Сургалтын төлбөрийн орлого | сая төг | 45,242.2 | 46,376.0 | 35,300.90 | 11,075.10 | 76.1 |
| 1.3 | Сургалтын бусад үйлчилгээний орлого | сая төг | 5,672.3 | 31,471.4 | 62,047.30 | -30,575.90 | 197.2 |
| 1.4 | Өөрийн үйл ажиллагааны орлого | сая төг | 7,884.5 | 1,456.0 | 2,722.10 | -1,266.10 | 186.9 |
| 1.5 | Үйл ажиллагааны бус орлого | сая төг | 4,398.8 | 508.8 | 1,181.20 | -672.4 | 232.2 |
| **2** | **Нийт зардал** | **сая төг** | **80,243.3** | **110,828.0** | **114,387.50** | **-3,559.50** | **103.2** |
| 2.1 | Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал | сая төг | 48,934.9 | 51,536.2 | 60,660.60 | -9,124.40 | 117.7 |
| 2.2 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | сая төг | 5,290.9 | 6,543.1 | 6,276.40 | 266.70 | 95.9 |
| 2.3 | Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал | сая төг | 3,292.7 | 3,786.8 | 3,674.10 | 112.70 | 97 |
| 2.4 | Хангамж, бараа материалын зардал | сая төг | 1,878.8 | 4,437.8 | 3,178.70 | 1,259.10 | 71.6 |
| 2.5 | Норматив зардал | сая төг | 8,736.7 | 11,716.8 | 11,993.20 | -276.40 | 102.4 |
| 2.6 | Эд хогшил худалдан авах зардал | сая төг | 2,952.5 | 5,756.6 | 3,076.10 | 2,680.50 | 53.4 |
| 2.7 | Томилолт, зочны зардал | сая төг | 436.8 | 934.9 | 642.6 | 292.30 | 68.7 |
| 2.8 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | сая төг | 2,165.1 | 2,826.8 | 2,171.80 | 655.00 | 76.8 |
| 2.9 | Бараа үйлчилгээний бусад зардал | сая төг | 5,667.3 | 6,570.5 | 21,949.50 | -15,379.00 | 334.1 |
| 2.10 | Бусад урсгал шилжүүлэг | сая төг | 887.6 | 1,857.7 | 764.5 | 1,093.20 | 41.2 |
| 3 | **Үр дүн** | **сая төг** | **434.9** | **0.0** | **10,897.7** | **10,897.7** | |
| 4 | **Нийт ажиллагсад** | **хүн** | **1460** | **1478** | **1460** | **18** | **98.8** |
| 5 | **Цалингийн сан** | **сая төг** | **48,934.9** | **51,536.2** | **60,660.60** | **-9,124.40** | **117.7** |
| 6 | **Нийт авлага** | **сая төг** | **21,982.2** | **-** | **12,179.2** | **-** | **-** |
| 7 | **Нийт өр төлбөр** | **сая төг** | **6,773.7** | **-** | **11,936.2** | **-** | **-** |
| 8 | **Нийт хөрөнгө оруулалт** | **сая төг** | **8,484.9** | **14,860.6** | **11,726.8** | **3,133.9** | **78.9** |
| 9 | **Үүнээс өөрийн хөрөнгөөр** | **сая төг** | **8,484.9** | **14,860.6** | **11,726.8** | **3,133.9** | **78.9** |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 1,083,596.2 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 41,242.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 735,061.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 307,292.4 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлэв.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

| Д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| **1** | **АШУҮИС** | | | | | | | | | | | | |
| 1 | Албан хаагчдын цалингийн шатлал, нэмэгдлийг зөрүүтэй тооцож илүү олгосон. | 1 | 7,071.6 | 1 | 7,071.6 | | | | | | | | |
| 2 | Байгууллагын төсвөөс 7.6 сая төгрөгийг бэлэг дурсгал, 2.8 сая төгрөгийг согтууруулах ундаа худалдан авахад зарцуулсан. | 1 | 10,433.3 | 1 | 10,433.3 | | | | | | | | |
| 3 | Татвар ногдох орлогоос ХХОАТ суутгаж төсөвт төвлөрүүлээгүй. | 1 | 1,750.8 | 1 | 1,750.8 | | | | | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | ТӨБЗГ болон 4 түрээслэгчтэй байгуулсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ"-ний үүргийн биелэлтийг тооцож, гэрээний дагуу алданги тооцож, түрээслэгчээс нэхэмжилж аваагүй байна. | 1 | 20,917.6 | 1 | 20,917.6 | | | | | | | | |
| 5 | Жолоочийн замын хөдөлгөөнд оролцох явцдаа гаргасан 50 удаагийн зөрчилд оногдуулсан торгуулийн төлбөрийг байгууллагын төсвөөс зориулалт бусаар зарцуулсан. | 1 | 643.9 | 1 | 643.9 | | | | | | | | |
| 6 | ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу ажил үйлчилгээ, бараа худалдан авалт хийхдээ сонгон шалгаруулалт явуулаагүй, шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн. | 1 | 683,031.2 | | | 1 | 683,031.2 | | | | | | |
| 7 | Ажил гүйцэтгэх гэрээгээр олгосон цалин хөлснөөс НДШ суутгаагүй. | 1 | 11,040.8 | | | 1 | 11,040.8 | | | | | | |
| 8 | Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж зардлаар хүлээн | 1 | 261,763.8 | | | | | 1 | 261,763.8 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд тусгасан. | | | | | | | | | | | | |
| 9 | Хангамж үйлчилгээний газрын 9360100426724, 9360100546422 тоот картаар хийсэн шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй, баталгаажуулаагүй баримтыг зардлаар хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд тусгасан. | 1 | 11,018.0 | | | | | 1 | 11,018.0 | | | | |
| | Дүн | 9 | 1,007,671.0 | 5 | 40,817.2 | 2 | 694,072.0 | 2 | 272,781.8 | | | | |
| 2 | АШУҮИС-ийн Дархан уул аймаг дахь Анагаах ухааны сургууль | 2 | 27,921.8 | 1 | 425.0 | | | 1 | 27,496.8 | | | | |
| 3 | АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь Анагаах ухааны сургууль | 1 | 5,100.0 | | | | | 1 | 5,100.0 | | | | |
| 4 | АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны сургууль | 2 | 0.00 | | | | | 2 | 0.00 | | | | |
| 5 | АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг | 5 | 42,903.7 | | | 2 | 40,989.8 | 3 | 1,913.9 | | | | |
| | Дүн | 10 | 75,925.5 | 1 | 425.0 | 2 | 40,989.8 | 7 | 34,510.7 | | | | |
| **Бүгд дүн** | | **19** | **1,083,596.5** | **6** | **41,242.2** | **4** | **735,061.8** | **9** | **307,292.5** | | | | |

**3.2** АДБОУС 400.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн 4 зөрчилд 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэв.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөг/

| Д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **1** | **Цалинтай холбоотой зөрчил** | | | | | | |
| | Лицей ахлах сургуулийн захирлыг сэлгэн ажиллуулахдаа эрх зүйн байдлыг дордуулж цалингийн шатлалыг ТҮМБ 7-оос ТҮБД 5 болгон бууруулан тогтоосон байна. | 1 | 0.00 | 1 | 0.00 | | |
| 2 | **Түрээсийн орлоготой холбоотой зөрчил** | | | | | | |
| | Тус сургууль түрээсийн гэрээний үүргийн биелэлтийг тухай бүр дүгнээгүйгээс 79.0 сая төгрөгийн түрээсийн төлбөрийг огт аваагүй. | 1 | 0.00 | | | 1 | 0.00 |
| 3 | **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | |
| | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 12 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт мэдээлээгүй. | 1 | 0.00 | 1 | 0.00 | | |
| 4 | **Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой зөрчил** | | | | | | |
| | Тайлант хугацаанд 8,828.4 сая төгрөгийн 45 удаагийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан боловч тендерийг холбогдох хууль, журам, зааврын дагуу үнэлсэн талаарх баримт материалыг иж бүрэн бэлтгэж, баталгаажуулаагүй, ил тод байршуулаагүй. | 1 | 0.00 | 1 | 0.00 | | |
| | **Дүн** | **4** | **-** | **3** | **-** | **1** | |
| | **Нийт дүн** | **4** | **-** | **3** | **-** | **1** | |